

**ACTA MONGOLICA**  
**CENTRE FOR MONGOL STUDIES**  
**National University of Mongolia**

Том. 1 (Ш)

2002

107-116

**“Дуутын хар чулуу”-ны монгол бичээсийн  
хэлний онцлог**

***Д.Заяабатар (МУИС)***

Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутаг дахь “Дуутын хар чулуу” [Дуутын хад] хэмээх өвөрмөц сонин тогтоцтой газар нь одоогоос дөрвөн зууны тэртээх монголын түүх, соёлын нэгэн чухал баримт дурсгалыг улируулан тээж, өдгөө бидний үед учран золгуулсан бөгөөд тэрхүү монгол бичээс нь судалгаа шинжилгээний эргэлтэд орсноос хойш 80 орчим жилийг ардаа орхижээ. Эл газрын хад чулуу нь бичээс сийлэхэд тохиромжтой гөлгөр бараан цохионууд байх ба ямар нэгэн зүйлээр цохиж дэлсэхэд хангинах дуу чимээ гардаг учир нутгийн олон тийн нэрлэж заншсан гэнэ.

Бид 2001 оны 6-р сарын 5-ны өдөр<sup>1</sup> Дуутын хаднаа уугуул нутгийн малчин хоёр залуугаар газарчлуулан хүрч, бичээсийн бодот байдалтай танилцан, шинээр хуулбар хийж авсан билээ.

Бичээсийн ерөнхий төлөв байдал өнөөг хүртэл тод гаргацтай хэвээр байгаа нь нэг талаас түүх соёлын дурсгалаа хайрлан хамгаалах ард олны үзэл гүн бат шингэснийх, нөгөө талаас Монголын хувь заяаны ээдрээтэй нэгэн үед Манжийн түрэмгийллийн эсрэг шийдвэртэй тэмцэж, эх орноо тусгаар тогтносон улс байх ёстой гэсэн хатуу байр суурийг барихын зэрэгцээ бийр янтай нийлүүлсэн бичиг номын мэргэн, бурханы шашныг тэтгэгч буяны өглөгийн эзэн байснаараа түүхэнд нэрээ мөнхөлсөн халхын Цогт тайжийн үйл хэрэгтэй салшгүй холбоотойн учир тэрхүү газрыг эрхэмлэн дээдлэх итгэл сэтгэлээс үүдэлтэй болов уу. Тиймээс бидэнд газарчлан очсон хоёр залуу буцахдаа, “хад чулууг мод төмрөөр цохих, бичээсийн ойр орчимд элдэв зүйл эрээчиж сараачихгүй байх”-ыг чухалчлан захиж байсан юм.

<sup>1</sup> МУИС-ийн МХСС-д Эх бичиг судлалын мэргэжлээр суралцаж буй оюутан нар 3-р дамжаандаа “бичвэр судлал”-ын дадлага хийдэг бөгөөд түүний үндсэн чиглэл нь Монгол нутаг дахь бичиг үсгийн дурсгалтай танилцах явдал байдаг. 2000-2001 оны хичээлийн жилийн дадлагыг эл тэмдэглэлийг бичигч, дэд доктор Ц.Баттулга-ын хамт хариуцан явсан юм.

Өгүүлэн буй дурсгалын эрдэм шинжилгээний эргэлтэд орсон түүх, судалгааны тоймыг товч дурдвал:

1912 онд эрдэмтэн В.Л.Котвич Монголд судалгааны ажлаар ирээд байхдаа Мишиг гүний хошууны "Дуутын хар чулуу" гэдэг газар бичигтэй хад байдаг тухай дуулсан боловч цагийн давчуугаас шалтгаалж, уг бичээсийг очиж үзэх бололцоо гараагүй учир тухайн үеийн Монгол улсын Гадаад яамны сайд, чин ван Ханддоржид хандаж, бичээсийг хуулан явуулахыг хүссэн ёсоор эрдэмтэн Жамсраны Цэвээнээр дамжуулан, уг дурсгалын хуулбарыг илгээснийг В.Л.Котвич хүлээн аваад, Оросын археологийн нийгэмлэгийн дорно дахины салбарын хуралдаан дээр анх удаа товч танилцуулсан ажээ.

1925 оны 9-дүгээр сард П.К.Козлов Түшээт хан аймгийн Мишиг гүний хошуугаар явах үедээ уул бичээсийг гэрэл зурагт буулгаж авчээ.

Хожим В.Л.Котвич, П.К.Козлов хоёр уг бичгийн хуулбар ба гэрэл зургийг нэрт монголч Б.Я.Владиморцовт өгч, эрдмийн ажилд нь найрсагаар тусалсны үрээр уг бичээсийг тусгайлан судлах боломж бүрдсэнийг тэрбээр өгүүлэлдээ онцлон дурдсан буй.<sup>2</sup>

Дээрх цуврал өгүүлэл<sup>3</sup> нь "Дуутын хар чулуу"-ны бичээсийг анх удаа эрдэм шинжилгээний үүднээс нарийвчлан судалсан бүтээлд зүй ёсоор тооцогдох үнэ цэнтэй зохиол болохыг далимд тэмдэглэе.

Түүнээс хойш "Дуутын хар чулуу"-ны "их бичээс"<sup>4</sup>-ийг гол төлөв яруу найраг, уран зохиолын дурсгал талаас нь академич Ц.Дамдинсүрэн, Д.Цэрэнсодном, профессор Ж.Төмөрцэрэн, Ц.Сандаг, Хишигтогтох, Ж.Дашдондог нар судлан шинжилжээ.<sup>5</sup>

"Дуутын хар чулуу"-ны бичээс нь монгол хэлний хөгжил хийгээд бичгийн хэлний түүхэнд холбогдох баримт болохын учир түүнд эх бичиг судлалын үүднээс илүү анхаарлаа хандуулахын сацуу уг дурсгалын хэлний онцлогийг тухайлан ажиглаж, хянан магадлах нь энэхүү товч тэмдэглэл бичигчийн зорилго билээ.

<sup>2</sup> **Б.Я.Владимирцов**, *Надписи на скалах халхаского Цокту-тайджи* /Статья первая/, Известия Академии Наук СССР, 1926, стр. 1253.

<sup>3</sup> **Б.Я.Владимирцов**, *Надписи на скалах халхаского Цокту-тайджи* /Статья первая/, Известия Академии Наук СССР, 1926, стр. 1253-1280; *Надписи на скалах халхаского Цокту-тайджи* /Статья вторая/, Известия Академии Наук СССР, 1927, стр. 215-240.

<sup>4</sup> "Дуутын хар чулуу"-ны гурван том сэрүүн цохионы баруун зүгт харсан босоо хаднаа сийлсэн 17 мөр монгол бичээсийг тийн нэрлэж байгаа бөгөөд нийтэд алдаршсанаар "Цогтын хадны шүлэг" болно.

<sup>5</sup> **Ц.Дамдинсүрэн**, *Монголын уран зохиолын дээж зуун билиг*, Улаанбаатар, 1959, 276-279-р тал; **Д.Цэрэнсодном**, *Монгол уран зохиол, XIII-XX зууны эх*, Улаанбаатар, 1987, 264-272-р тал; **Д.Цэрэнсодном**, *Цогтын чулууны бичгийг уншсан тэмдэглэл*, ШУА-ийн мэдээ, №4, Улаанбаатар, 1974, 98-102;

**Jo.Temürçering**, *Sbytu tayij-yin biäg*, Өнөр цэцэг, 1958, №1; **Ц.Сандаг**, *Цогтын хадны шүлэг*, Монголын уран зохиолын тойм, II, редактор Ц.Дамдинсүрэн, Д.Цэнд, Улаанбаатар, 1977, 36-44; **Kesigtoytaqu**, *Erten-ü mongyol silüg-ün tegübüri*, Köke qota, 1985, 366-376; **Ж.Дашдондог**, *Халхын Цогт хунтайж*, Улаанбаатар, 1992.

Өгүүлэн буй дурсгалын он цагийн хамаатал нь XVII зууны эхэн хагас буюу дунд бичээст<sup>6</sup> тэмдэглэснээр “*änggis qayan-u üre [ür-e] Vär qayan-u aä qalqayin [qalq-a-yin] Coy-tu [öoytu] tayjiin [tayiβyin] jariiy-iyar Dayiäng kiy-a Güyeng bayatur qoyar mongyol-un Qutuy-tu qayan-u ucira, Önggis qayan-i [qayan-u] törügsen usun morin β-eöe inaysi dörben jäyun Jran dörben β boluysan-a β-ün eki modun quluyuna [quluyan-a] β, sarayin [sar-a-yin] eki yal bars sarayin [sar-a-yin] arban tabun yeke cayan edür-e, qas erdeni metü qadan-tur [qadan-dur] biäbei*” болох бөгөөд тэр нь аргын **тооллын 1624 онд тохиодог. Үүнээс үзээл, уг бичээсийг хаднаа сийлсэн** цаг үе нь хэлний хөгжлийн түүхийн хувьд орчин цагийн монгол хэл, бичгийн хэлний хувьд сонгодог бичгийн эхэн үед хамаарах ажээ.

"Дуутын хар чулуу"-ны бичээсийн эх хуулбарыг тулгуур болгон, мөр бүрээр нь дугаарлаж, галиглан сийрүүллээ. Чингэхдээ орчин үеийн монгол бичгээс өөр зарчмаар бичсэн үгсийн ард зохих хэлбэрийг нь оноон хадаж, нэмэн тодруулсан учраа өчсү.

Бас нэгэн дурдах зүйл, нэрт эрдэмтэн Б.Я.Владимирцов, уг дурсгалтай өөрийн биеэр очиж танилцаагүй зөвхөн гэрэл зураг, монгол бичээчийн авсан хуулбарыг гол хэрэглэгдэхүүн болгон уншсан учир зарим үгийг бага зэрэг ташаарч буулгасан байдал таарч байгааг эх бичиг судлалын үүднээс засан залруулах нь зүйтэй хэмээн бодож, тулган нягталсан юм.

#### **Их бичээсийн галиг:**

1. Cayan takiy-a jil-ün [Аргын тооллын 1621 он. Д.3] namur-un ekin sarayin [sar-a-yin] qorin nigen-e, Coy-tu [Coytu] tayiji Qangyai qan-u cecerlig-ün
2. qoyitu ayulan-tu [ayulan-du], abalan quyay-tu qaltar-iyar unuyad öndür degere [deger-e] yarcu bayiqudayan [bayiqu-dayan] jegün jüg qaran
3. sedkil-iyen masi uyaraжу qalayutu abaya [abay-a] egeci-yügen sanaju eyin ögüleged uyila-luy-a [ukilaluy-a]. degere [deger-e] tengri [tngri] qan-u
4. aqu kiged, delekei teki [deki] qan boydosun [boydas-un] aqu yajar degere [deger-e] doruyin [door-a-yin] ilyal bolbasu berjiryal qayiralal qoyar-un
5. ayar-a<sup>7</sup> nigen bui. Ayanistayin [ayanista-yin] ayui taki [daki] bodisung<sup>8</sup> nar kiged, altan delekei teki [deki] bodi sedkil-ten [sedkilten] qoyar-un
6. aqu yajar anggida bolbasu asaraqу nigülesküyin [nigüleskü-yin] ayar-a nigen bui, ende qan boydosun [bodyas-un] sayin түsimed kiged

<sup>6</sup> Өмнө зүгт харсан налуу хадны 8 мөр бичээсийг хэлж буй бөгөөд түүнд уг дурсгалыг сийлсэн эзэн, он цаг зэргийг тодруулах мэдээ зангийг тодорхой дурдсан байдаг.

<sup>7</sup> “Төв, агаар, чанар” гэсэн утгатай. Төвд хэлнээ *^i dbyings* [санскрит: *dhātu*], **Sumadiradna**, *Töbed mongyol-un dokiyan-u biäg ner-e üge udq-a yurba-yi todurayulun qarangqui-yi arilyayä juia orosiba*, Ulaanbaatar, 1959, 305-р тал.

<sup>8</sup> Б.Я.Владимирцов “*bodistv*” гэж буулгажээ. Нэгдүгээр өгүүллийн 1256-р талаас үзнэ үү.

7. eregülegci erlig qayan-u yeke noyad qoyar-un yosu öngge obere [öber-e] bolbasu jöb buruyugi [buruyu-yi] ilyaquyin [ilyaqu-yin] ayara nigen bui.
8. olja idesi olun yadayci kümün kiged, ayula modun-tu [modun-du] yabuyci ariyatan qoyar-un aqu bey-e anggida bolbasu
9. alan ideküyin [idekü-yin] ayar-a nigen bui. qola oyira-aca qulayai kigci kümün kiged, qoto-yi [qota-yi] ergin getegci cinu [cinu-a] qoyar-un
10. ilete [iledte] bey-e düri obere [öber-e] bolbasu, ideküi küsekü sedkil-ün ayara nigen bui.
11. onun mören-dü aqu qalayutu egeci mini kiged, orqun tuyuladu [tuula-du] ayци ebecitü
12. bide qoyar, qalq-a ongniyud-un yajar qola bolbasu ber, qayiralan sanalcaqu-yin
13. ayar-a nigen bui-j-a. ene beyendegen [bey-e-degen] ese jolyulcabasu egün-ece qoyidu törül tütüm [tl: twidwm]-
14. -düryen [tutum-dur-iyen], eke inü yayca keüken-iyen qayiralaqu metü, eldeb üile-ber tusalalcaqu<sup>9</sup>
15. boltuyai. kemen qayilan<sup>10</sup> ögülegsen-i inü qamtu aysan Erke kiy-a toytoyoju [toytayaju]
16. sudurlan abuyсан-i, qoyina [qoyin-a] dörben jil boluyad mön quluyuna [quluyan-a] jil-ün [Аргын тооллын 1624 он Д.3] nigen
17. sarayin [sar-a-yin] arban naiman-a, Dayicing kiy-a Güyeng bayatur qoyar qadan-du bicibei.

#### Дунд бичээсийн галиг:

1. Samandabadari<sup>11</sup> kiged Amindaw-a<sup>12</sup> ba Sigemüni burqan-a mörgümü.

<sup>9</sup> Б.Я.Владимирцов “*tusalcaqu*” гэж буулгажээ. Нэгдүгээр өгүүллийн 1257-р талаас үзнэ үү.

<sup>10</sup> Энд гарах “*qayilan*” хэмээх үг “чанга дуугаар өгүүлэх” гэсэн утгыг илтгэж буй. Үүнээс гадна дундад үеийн монгол хэлний дурсгалд “орилох, хашхирах” гэсэн утгаар тохиолддог. “*Мукаддимат ал-Адаб*” толинд “*qailaqu*” (хашхирах ‘кричат’) хэмээн тэмдэглээд, “*qailaji ungsiba qurāni*” (читал коран высоким голосом \*Коран сударыг өндөр дуугаар уншив) гэх мэт жишээ татжээ.

" Samantabhadra, Төвд: Т5<sup>чэс:ч1</sup> 1. Имя первого дхъяни-бодхисаттвы;

2. Ади-будда (начальный Будда секты ^^^^). **Ю.Н.Рерих**, *Тибетско-русско-английский словарь с санскритскими параллелями*, Выпуск 1, Москва, 1983, стр. 20.

<sup>12</sup> Самгарди: Amithabha; Төвд: ^^Я^, “цаглашгүй гэрэлт”. Язгуурын таван бурханы нэг, урт насны шид уддис соёрхогч Авид бурхан. **О.Сүхбаатар**, *Монгол хэлний харь үгийн толь*, Улаанбаатар, 2000, 23-р тал.

Kyi vcir<sup>13</sup>

2. kiged Varakei<sup>14</sup> eke ba Bajar bani-tu mörgümü. Degedü tngri kiged
3. qayan qatun ba aliba acitan kümün-e mörgümü. oum mani bad me qung.
4. oum mani bad me qung. oum mani bad me qung. oum mani bad me qung. oum mani bad me qung. oum mani bad
5. me qung. Cinggis qayan-u üre [ür-e] Vcir qayan-u<sup>15</sup> aci qalqayin [qalq-a-yin] Öoy-tu [Coytu] tayijiin [tayiji-yin] jarliy-iyar Dayicing kiy-a Güyeng
6. bayatur qoyar mongyol-un Qutuy-tu qayan-u<sup>16</sup> ucira, Öinggis qayan-i [qayan-u] törügsen usun morin jil-ece [Аргын тооллын 1162 он. Д.3] inaysi
7. dörben jayun jiran dörben jil boluysan-a jil-ün eki modun quluyuna [quluyan-a] jil, sarayin [sar-a-yin] eki yal bars
8. sarayin [sar-a-yin] arban tabun yeke cayan edür-e, qas erdeni metü qadan-tur [qadan-dur] bicibei.

#### Бага бичээсийн галиг:<sup>17</sup>

1. Dayicing kiyagiin (kiy-a-yin) degü (degüü)
2. Amur kiy-a bicibei

Монгол бичгийн хэлийг үечлэн хуваах асуудалд анхаарлаа хандуулж, судалгаа шинжилгээний бүтээл туурвисан эрдэмтэд XVII зууны үеийн бичгийн хэлэнд төвд хэлний зүйн нөлөө тусгал их байгааг тухайлан тэмдэглэсэн буй.

Энэхүү нийтлэг зүй тогтолт үзэгдэл нь цаг хугацааны хувьд “Дуутын хар чулуу”-ны бичээст хамаарах боловч хэл найруулгын талаараа монгол бичгийн хэлний үндсэн онцлогийг хадгалсан, утга санаа үлэмж гүн, үг хэллэг нэн тодорхой, тэгш эерүү шинжтэй байдаг. Үүний учир нь уг шүлгийг зохиогч, бичээсийг хаднаа сийлэгч хүмүүсийн

<sup>13</sup> Хээбазар [Hevajra]. Төвд: <sup>ʌ</sup>ä | <sup>Q</sup>ʌ | Баясагч очир хэмээсэн үг. Тарнийн дандарын тэнцэшгүй дээд догшин ядмын нэр. Гэлүмбагийн таван их догшин ядмын нэг. **Ш.Чоймаа, Л.Тэрбиш нар**, *Буддын шашин, соёлын тайлбар толь*, Хоёрдугаар дэвтэр, Улаанбаатар, 1999, 437-ртал.

<sup>14</sup> чпуя] <sup>v</sup>ärähT. 1. Свинья, свиноматка; <sup>ʌ</sup>g<sup>4</sup>ʌ | <sup>J</sup>ʌ | vajravärähI. Ваджраварахи (имя богини буддийского пантеона, эманации Вайроганы и шахты Самвары по поверью воплощающаяся в настоятельницу монастыря Самдинг в Центральном Тибете). **Ю.Н.Рерих**, *Тибетско-русско-английский словарь с санскритскими параллелями*, Выпуск 6, Москва, 1986, стр. 20.

<sup>15</sup> Автай ханыг хэлж буй.

<sup>16</sup> Лигдэн хутагт хааныг хэлж буй.

<sup>17</sup> Их бичээсийн чанх дээрх налуу хаднаа буй ланз, төвд, нангиад, монгол бичээсийг хэлж байна. Ланз, төвд нь маанийн үсэг байх ба хятад бичээсийг академич Д.Цэрэнсодном "Хичээнгүй ёсолсон балчир хөвүүний зүс царай нь үзэсгэлэн бөгөөд өлзийтэй" хэмээн орчуулжээ. **Д.Цэрэнсодном**, *Цогтын чулууны бичгийг уншсан тэмдэглэл*, ШУА-ийн мэдээ, №4, Улаанбаатар, 1974, 100-р тал.

боловсрол, сийлсэн цаг үе, орчин нөхцөл зэрэг хүчин зүйлтэй шууд холбоотой.

Ер нь XVII зууны эхэн хагаст хад чулуунаа сийлэн бичсэн дурсгал тун ховор буй. Тийм учраас эл бичээс нь монгол бичгийн үсэгзүйн хөгжил хувирлын нэгэн чухал баримт болохын учир үсгийн тиг зурам нь өвөрмөц сонин хэлбэртэй, жигд хичээнгүй байх ажээ. Нөгөөтэйгүүр, сонгодог бичгийн өмнөх үеийн дурсгалд олонтаа тохиолддог зарим онцлог хэлбэр уламжлан хэрэглэгдэж байсныг тодлох баримт таарах хийгээд үсгийн нэмэлт тэмдгийн хувьд, таслалын оронд хоёр цэг, утга санаа бүрэн төгссөн мөчлөгийн эцэст дөрвөн цэг талбисан байна.

Бичээсийн эхийг хянан магадлах явцад XVII зууны үеийн монгол хэлний төлөв байдлыг илтгэсэн өвөрмөц онцлогтой зүйл тохиолдох ажээ. Онцлон дурдвал:

1. Эгшгийн ижилслийг харуулах баримт гарч байна.

**MMS** [Modern mongolian script]: *qota-yi* -> **Ins I** [Inscription I]<sup>18</sup>: *qoto-yi*

**MMS**: *tgytayafo* -> **Ins I**: *toytoyofa* [тогтоож]

**MMS**: *boydas-un* ^ **Ins I**: *bgfoos-un* [богдосын]

2. Тийн ялгалын нөхцөлийг ихэнх тохиолдолд өмнөх үгтэй залган бичсэн нь сонгодог монгол бичгийн уламжлалаас ирэл үүдэлтэй боловч ярианы хэлний онцлог шууд дулдуйдан шүтсэнийг илтгэж буй хэрэг.

**MMS**: *sar-a-yin* **Ins I**: *sarayin* [сарын]

**MMS**: *baiyiqu-dayan* -> **Ins I**: *baiqudayan* [байхдаа]

**MMS**: *ayanista-yin* **Ins I**: *ayanistayin* [агнистын]

**MMS**: *nigüleskü-yin* -> **Ins I**: *nigülesküyin* [нигүүлсэхийн]

**MMS**: *qalq-a-yin* -> **Ins II**: *qalqayin* [халхын]

**MMS**: *tayiji-yin* -> **Ins II**: *tayifon* [тайжийн]

3. Монгол бичгийн хэлний харьяалахын тийн ялгалын -и/-й нөхцөлийг ярианы хэлэнд -Т-ээр дууддаг болсоныг тодлох баримт таарч байна. Чингэж тэмдэглэсэн хэлбэр XVII зууны үед зохиогдсон монгол түүхэн сурвалжуудад цөөнгүй тохиолддог билээ.<sup>19</sup>

**MMS**: *qayan-u* -> **Ins II**: *qayan-i* [хааны]

4. Сонгодог монгол бичгийн хэлэнд байгаагүй, хоёр эгшгийг зааглах үүрэгтэй жийрэглэн ордог гийгүүлэгч тухайн үед нэгэнт буй болсон байжээ гэдгийг нутлах баримт дайралдах ажээ.

**MMS**: *fob buruyu-yi* -> **Ins I**: *fob buruyugi* [зөв бурууг]

**MMS**: *kiy-a-yin* -> **Ins III**: *kiyagiin* [хиагийн]

<sup>18</sup> "Их бичээс"-ийг **Ins I** [Inscription I]; "Дунд бичээс"-ийг **Ins II**; "Бага бичээс"-ийг **Ins III** гэж товчлон тэмдэглэв.

<sup>19</sup> Ц.Шагдарсүрэн, XVII зууны үеийн монгол хэлийг судлах аргазүйн асуудалд, The 13<sup>th</sup> International Conference KOREA and MONGOLIA, Seoul, 2001, 67-72; Д.Заяабаатар, "Асрагч нэртийн түүх"-ийн хэлний онцлогийн тухайд, The 14<sup>th</sup> International Conference KOREA and MONGOLIA, Ulaanbaatar, 115-121.

Үүнээс гадна, монгол бичгийн хэлний зөв бичих зүйн тулгуур зарчмын нэг болох чанга, хөндийн зохицол нь XVII зууны үеийн монгол хэлний зарим аялгуунд зөвхөн эгшгээр зогсохгүй холбох үгийн тухайд нэн тод байсныг илтгэх сонирхолтой жишээ баримт тохиолдож байна.


*MMS: törül tutum-dur-iyān -> Ins I: törül tütüm-düryen*  
[төрөл тутамдаа] [төрөл түтэмдээ]

Өмнө дурдсан мэт хэдэн зүйл нь өнөөгийн үүднэс буюу орчин үеийн монгол бичгийн зөв бичих зүйн талаас “алдаа” мэт боловч тэрхүү хэлбэр байдал нь тухайн цагийнхаа ярианы хэлний онцлог шинжийг гол тулгуур болгож, түүнийг шууд тусган тэмдэглэснээс үүдэлтэй хэмээн үзэх үндэстэй бөлгөө.

XVII зууны монгол хэлний онцлог байдлыг тэнхрүүлэн сэргээх баримт хэрэглэгдэхүүний хүрээ хязгаар баяжин тэлэхэд “*Дуутын хар чулуу*”-ны бичээс нь багагүй хувь нэмэртэй гэдгийг дурдах ташрамд түүний тул жинхэнэ эх бичгийг тулгуур үндэс болгож, судалгаа шинжилгээний бүтээлд эшлэн ашиглаж байвал зохистой хэмээн санасны учир энэхүү тэмдэглэлийг нуршин бичсэн билээ.

### ХОЛБОГДОХ ном зохиол

1. **Владимирцов Б.Я.**, *Надписи на скалах халхаского Цокту-тайджи* [Статья первая], Известия Академии Наук СССР, 1926, стр. 1253-1280; [Статья вторая], 1927, стр. 215-240.
2. **Дамдинсүрэн Ц.**, *Монголын уран зохиолын дээж зуун билиг*, Улаанбаатар, 1959.
3. **Дашдондог Ж.**, *Халхын Цогт хунтайж*, Улаанбаатар, 1992.
4. **Заяабаатар Д.**, “*Асрагч нэртийн түүх*”-ийн хэлний онцлогийн тухайд, The 14<sup>th</sup> International Conference KOREA and MONGOLIA, Ulaanbaatar, 115-121.
5. **Поппе Н.Н.**, *Монгольский словарь Мукаддимат ал-Адаб*, Москва-Ленинград, часть I, II, III, 1938.
6. **Рерих Ю.Н.**, *Тибетско-русско-английский словарь с санскритскими параллелями*, Выпуск 1, Москва, 1983; Выпускб, Москва, 1986.
7. **Сандаг Ц.**, *Цогтын хадны шүлэг*, Монголын уран зохиолын тойм, II, редактор Ц.Дамдинсүрэн, Д.Цэнд, Улаанбаатар, 1977, 36-44.
8. **Sumadiradna**, *Töbed mongyol-un dokiyan-u biäg neg-e üge udq-a yurba-yi todurayulun qarangqui-yi arilyayä juta orosiba*, UB, 1959.
9. **Сүхбаатар О.**, *Монгол хэлний харь үгийн толь*, Улаанбаатар, 2000.
10. **Temürcering Jo**, *Coytu tayji-yin biäg*, Өнөр цэцэг, 1958, №1.
11. **Kesigtoytaqu**, *Erten-ü mongyol silüg-ün tegübüri*, Köke qota, 1985.
12. **Цэрэнсодном Д.**, *Монгол уран зохиол, XIII-XX зууны эх*, Улаанбаатар, 1987.
13. **Цэрэнсодном Д.**, *Цогтын чулууны бичгийг уншсан тэмдэглэл*, ШУА-ийн мэдээ, №4, Улаанбаатар, 1974, 98-102.
14. **Чоймаа Ш, Тэрбиш Л нар**, *Буддын шашин, соёлын тайлбар толь*, Хоёрдугаар дэвтэр, Улаанбаатар, 1999.
15. **Шагдарсүрэн Ц.**, *XVII зууны үеийн монгол хэлийг судлах аргазүйн асуудалд*, The 13<sup>th</sup> International Conference KOREA and MONGOLIA, Seoul, 2001, 67-72.



Их бичээсийн ерөнхий байдал




## Хавсралт №2



Дунд бичээсийн ерөнхий байдал

### Хавсралт N°3



Бага бичээсийн ерөнхий байдал